

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2015 оны 04-р сарын 25

Улаанбаатар хот

“Барилга” ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит хурлыг /цаашид ХЭХ гэх/ байгууллагын хурлын танхимд ТУЗ-ын нарийн бичгийн дарга хурлын ирц танилцуулсанаар 10.00 цагт гишүүдийн 98 хувийн ирцтэй эхлэв. Хуралд хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ын хараат бус гишүүдээс гадна Монголын Хөрөнгийн Биржийн ажилтан ажиглагчаар оролцов.

ХЭХ-ыг ТУЗ-ын дарга Л.Шагдаррагчаа нээж хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, ТУЗ-с гаргасан тогтоол, хурлын дэгийг танилцуулав. Дэгийг 100 хувь батлав. Хуралд оролцогсод бүх тайлантай танилцсаны дараа асуулт хариулт, санал шүүмжлэлүүдийг хэлэлцэхээр тохиролцов.

ТУЗ-ийн дарга Л.Шагдаррагчаа ТУЗ-ын тайланг уншиж танилцуулав. Тайланг хавсаргав.

Үүний дараа Гүйцэтгэх захирал Ш.Эрдэнэбат байгууллагын тайлант оны үйл ажиллаганы үр дүн болон ирэх оны үйл ажиллаганы чиглэлийн талаархи тайланг уншиж танилцуулав. Тайланг хавсаргав.

Гүйцэтгэх захирлын дараа НяБо А.Мөнхцоож 2013 оны санхүүгийн тайланг танилцуулав. Дөлгөөн Хайрхан Уул Аудитын дүгнэлтийг болон тэндээс өгөгдсөн зааварчилгаа, зөвлөмжүүдийг мөн уншиж танилцуулав. Зааварчилгаа зөвлөмжүүдийн дагуу өгөгдсөн хариулт, тайлбаруудыг давхар танилцуулав.

Бүх тайлангууд танилцуулагдсаны дараа асуулт хариултын хэсэгт оров:

Г.Болд: Алдагдлын шалтгаан?

Ш.Эрдэнэбат: ИТА нараа АНУ руу аялуулсан, 11-р сараас ажил зогссонтой холбоотой сул зогсолтын зардал гарсан, оффисын засварт мөнгө зарцуулсан, барилгачдын баяраар шагнал урамшуулал, машин техникийн эдэлгээнээс шалтгаалж явуулахгүй, замын хөдөлгөөнд оролцуулахгүй байсан тул тэдгээрийг актласан. Мөн Оюу Толгой төсөл дээр хийсэн зарим ажлын хөлс оны эцсээр тасалбар болоод орж ирээгүй, Оюу Толгой төсөл дээр материал нь ирээгүй байсан тул нэгэнт оччихсон ажилчидаа тэнд байршуулж цалинжуулсан гэх мэт зардлууд гарсанаас болж алдагдалд хүрсэн.

Г.Болд: Гэр хорооллын барилгажилтын төслөөс хэдийг олно гэж байгаа вэ?

Л.Шагдаррагчаа: Гэр хорооллын барилгажилтын төслийн зураг төсөл хийгдэж байгаа. Өөрийн мөнгөөр барилгыг барина. 4 байранд 500 айлыг шингээчихвэл үлдсэн талбайд нь бид байр барих, уламаар тэдгээр байраа зарж оруулсан мөнгөө эргэлтэд оруулах нөхцөл бүрдэнэ. Гэхдээ барилгын үнэ унчихаад байгаа энэ үед одоогийн зах зээлийн байдлыг харж байж нарийн тооцооллоо гаргана даа.

Г.Болд: Төлөвлөлтөд тавьсан тоон үзүүлэлтийг бодит болгох, төлөвлөгөөндөө хүрэх бодит боломж юу байна?

Л.Шагдаррагчаа: Авто зогсоол барих газрыг дуудлага худалдаагаар авчихсан, газар эзэмших гэрчилгээг нь нэр дээрээ болгуулж авсан байгаа. Энд баригдах зогсоолын зураг төсөл нь хийдэх шатанд явж байна. Эндээс ашиг олох боломжтой. Мөн хойно байдаг билльард клубын барилгын оронд бизнес төвийн барилга барина, зураг төсөл нь хийгдчихсэн байгаа. Эрчим хүчний яам дээр л хүлээгдэж байна, тэндээс гарчихвал ажлыг эхлэхэд асуудалгүй. Нөхцөл байдлыг харж байгаад уг ажлыг эхлэнэ. Үүн дээр мөн зах зээлийн байдлыг харж байж хөрөнгө оруулна. Бидний санхүүгийн эх үүсвэр болгох барьцаа хөрөнгө бэлэн байгаа.

Ш.Үнэнбат: Оюу Толгойн төслийн ажлын тендерт орсон гэсэн ямар үнийн дүнтэй өгсөн бэ?

Ш.Эрдэнэбат: Манлай суманд баригдах спорт цогцолборын ажлын үнийн саналыг тав дахь удаагаа өөрчилж 2,5 тэрбум болгож өглөө. Мөн Ханбогд сумын замын хажуугийн үерийн усны хоолойн ажил мөн байгаа гурван зуун саяын үнийн дүнтэй.

Өөр асуулт гарсангүй. Саналын хэсэг рүү шилжихээс өмнө хувьцаа эзэмшигч

Ш.Үнэнбат гэр хорооллын байрилгажилтын төслийн талаар товч танилцуулж мэдээлэл өгөв: Энэ төсөл байгууллага, хувь хүмүүст нийгмийн хариуцллагаа хэрэгжүүлэх, оршин суугчдын амьдралын түвшинг дээшлүүлэх боломж юм. Хотын төвөөс 1,8 км-т байрших газар. Энэ жил 2 блок үйлчилгээний төв, 4 орон сууцны барилга барих төлөвлөгөөтэй байна. Бид Барилга ХК-д санал тавьсан. Энэ төсөлд орсоноороо өөрсөддөө ажил бий болгох, ажилчидаа завгүй байлгах, бидний ажилд ч тус дөхөм болно ийм боломжууд харагдаж байна.

Энэ төслийн талаар асууж тодруулах зүйл гарав:

Б.Батцагаан: Дэд бүтэц нь яах уу?

Ш.Үнэнбат: Инженерийн шугам сүлжээний зураг төсөл нь хийгдэж байгаа. Зураг төслийг нь батлуулаад хотоос мөнгөө авна. Зөвхөн дулааны эх үүсвэр хүрэхгүй байгаа тул одоогоор уурын зуух барихаар байгаа юм. Энэ жил 1 уурын зуух, 1 цахилгааны эх үүсвэр барьчихсан байхад болно. Тэнд байгаа газраа чөлөөлсөн оршин суугчдыг байранд нь оруулчихсан байхад үлдсэн байруудыг зарах нь манай өөрийн шийдэх асуудал болно.

Санал:

Ж.Жадамба: Түрүү нь ярьсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн /НББ-ийн БББ/ хувьд аудитын байгууллагууд тэгэж хэлээд бид НББ-ийн БББ-г чинь гаргаж өгье гээд мөнгө авах гээд байдаг юм. Ингэхийн оронд Сангийн Яамнаас гаргасан нэг баримт бичиг байдаг тэрийг өөрийнхөө компанийн нөхцөл байдал, онцлогт тохируулж өөрчилж авахад болно, тэнд тусгагдсан бэлэн маягтуудыг аваад жаахан өөрчилөхөд л танай байгууллагын НББ-ийн БББ бэлэн гэсэн үг.

С.Тунгалаг: Ил тод байдлын болон санхүүгийн өршөөлийн тухай хууль батлагдвал балансаа цэвэрлэж цэгцлэх асуудал дээр нэлээн анхаарч ялангуяа ГУ-ын зүгээс албан ёсны комисс томилж нэлээн няхуур ажлах нь зүйтэй. Хэдэн тоо цаасан дээр өөрчлөөд дуусчих асуудал биш гэдгийг санаарай.

Үүнээс гадна ТУЗ-ын дарга Л.Шагдаррагчаа хараат бус гишүүн Ж.Жадамбын зүгээс байнга дэмжиж ажилладагт тэр дотроо Эрсдлээс урьдчилан сэргийлэх журам боловсруулж өгсөнд талархаж байгаагаа илэрхийлж, энэ асуудал, журамтай танилцаж судлаж байгаа гэв.

МХБ-ээс суусан ажилтнаас асуух зүйлгүй гэв. Манай цөөхөн тооны хувьцаа эзэмшигч хэдэн хүн өмнөх бидэнд өгсөн хаягууд дээрээ байхаа болисон, утаснууд нь солигдсон, холбогдохгүй байгаа ба энэ талаар тухайн иргэдийн тухай мэдээлэл олж өгч туслахыг хүсэж МИБМТ, Хувьцааны төвлөрсөн тооцооны төвүүдэд албан бичиг хэд хэдэн удаа хүргүүлсэн боловч үр дүн гараагүй талаар мэдээлэв.

Хувьцаа Эзэмшигчдэд урьдчилан тараасан тогтоолын төслүүдэд найруулга, засвар хийх, нэмэлт өөрчлөлт оруулах, татгалзсан санал гараагүй тул тогтоолуудын төслийг 100 хувийн саналаар батлав.

ГУ болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг хэвээр нь ажиллуулахаар санал нэг байсан тул саналын хуудсаар, кумулятив аргаар санал хураалт хийх шаардлагагүй гэж үзэв.

Өөр санал гарсангүй, хурал 12.00 цагт дуусав.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.ШАГДАРРАГЧАА

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



З.КУРАЛАЙ